



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/214

Улаанбаатар хот

Г “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн Г
өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн
газрын барилга байгууламжийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 66 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/653 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтүүдээр ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хавсралтад заасан нийт 23,698,489 /хорин гурван сая зургаан зуун ерэн найман мянга дөрвөн зуун наян есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 6 ус түгээх байрыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /Ц.Төрхүү/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 550.000 /таван зуун тавин мянган/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын нийслэлийн Төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэх, акт болон бусад баримт бичгийн бүрдэлтэд хяналт тавьж ажиллахыг Урт цагаан үйлчилгээний төв /П.Батжаргал/-д даалгасугай.

3. Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийхийг “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /Ц.Төрхүү/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000527

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын
 2020 оны .05. дугаар сарын .12. өдрийн
 01214... дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Ашигласан жил	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Мэргэжлийн улсын байцаагчийн дүгнэлт	Түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах үнэ
1	Ус түгээх байр-75	Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо	18	9,458,527.7	859,866.1	8,598,661.6	2019 оны 02-07-383/1583 дугаар дүгнэлт	95,000.0
2	Ус түгээх байр-85	Сүхбаатар дүүргийн 17 дугаар хороо	8	613,948.6	153,487.2	460,461.4	2019 оны 02-07-383/1583 дугаар дүгнэлт	85,000.0
3	Ус түгээх байр-165	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо	11	3,663,880.2	333,080.0	3,330,800.2	2019 оны 02-07-136/1719 дүгээр дүгнэлт	85,000.0
4	Ус түгээх байр-252	Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороо	20	5,920,606.9	592,060.7	5,328,546.2	2019 оны 02-07-101/1831 дүгээр дүгнэлт	95,000.0
5	Ус түгээх байр-315	Хан-Уул дүүргийн 6 дугаар хороо	48	1,294,196.4	431,398.8	862,797.6	2019 оны 02-07-395/1828 дугаар дүгнэлт	95,000.0
6	Ус түгээх байр-23	Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо	18	2,747,329.2	686,832.2	2,060,497.0	2020 оны 02-07-095/202 дугаар дүгнэлт	95,000.0
	Актлах барилга, байгууламжийн дүн			23,698,489.0	3,056,725.1	20,641,763.9		550,000.0